

АЖЛЫН ДААЛГАВАР

2025 оны 05 дугаар сарын 09-ний өдөр

Улаанбаатар хот

Хугацаа: Хуанлийн 105 хоног, ажлын 71 өдөр

Эхлэх
хугацаа: 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдөр

Дуусах
хугацаа: 2025 оны 09 дүгээр сарын 12-ны өдөр

Зорилго	Уул уурхайн салбар дахь авлигын эрсдэлийн үнэлгээний аргачлал боловсруулах, аргачлалыг ашиглах зөвлөмж бүхий үлгэрчилсэн заавар бэлтгэх
Үндэслэл	• Авлигын эсрэг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.12-т “бүрэн эрхийнхээ хүрээнд авлигын шалтгаан нөхцөлийг илрүүлэн тогтоох, тэдгээрийг арилгах, авлигын үйлдлийг таслан зогсоох, үр дагаврыг нь арилгах арга хэмжээ авах” гэж заасан. • УИХ-ын 2023 оны 59 дүгээр тогтоолоор батлагдсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийн 2.6.1-д “Салбар дахь үйл ажиллагааны эрсдэлийг үнэлэх аргачлалыг боловсруулж, үнэлгээ хийнэ” гэж заасан. • УИХ-ын 2024 оны 46 дугаар тогтоолоор батлагдсан Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний 2.6.1.1-д “Салбар дахь үйл ажиллагааны эрсдэлийг үнэлэх аргачлал боловсруулж, үнэлгээ хийх” гэж заасан. • Тухайлсан салбарын авлигын эрсдэлийн түвшнийг олон улсын сайн туршлагад суурилсан, шинжлэх ухаан, технологи, инновацыг нэвтрүүлсэн, салбарын үйл ажиллагаа, чиг үүрэг, онцлогт тохирсон аргачлалыг боловсруулан үйл ажиллагаанд ашиглах хэрэгцээ шаардлага үүссэн.
Зөвлөхийн гүйцэтгэх ажил	Зөвлөх баг дараах ажлыг гүйцэтгэнэ: • Салбарын бүтэц, үйл ажиллагааг тодорхойлох, бүдүүвч зураглал гаргах; • Салбарын эрх зүйн орчныг судлах, дүн шинжилгээ хийх, зураглах; • Салбар дахь авлигын эрсдэл бүхий байгууллага, үйл ажиллагаа, эрх зүйн зохицуулалтыг тодорхойлох; • Салбар дахь авлигын эрсдэлийг хэмжих үзүүлэлтүүд, тэдгээрийг хэмжих аргачлалыг тодорхойлох; • Бусад улс орон, олон улсын байгууллагаас гаргасан, ижил төстэй салбар дахь авлигын эрсдэлийн үнэлгээний арга зүй, аргачлал, сайн туршлагыг судалж, Монгол Улсын нөхцөл байдалд нийцүүлэн ашиглах боломжийг тодорхойлох;

	• Аргачлал болон үлгэрчилсэн зааварт өгөгдөлд суурилсан үнэлгээ, цахим платформ, эрсдэлийн оношилгооны автоматжуулсан арга хэрэгсэл, дижитал тайлагнал зэрэг технологийн шийдлүүдийг тусгах боломжийг судлах; • Авлигын эсрэг хууль болон холбогдох бусад хууль, бодлого, хөтөлбөрүүдтэй уялдсан, хэрэгжих боломжтой, хууль зүйн үндэслэлтэй аргачлал боловсруулах, аргачлалыг хэрэгжүүлэх үлгэрчилсэн заавар бэлтгэх; • Салбар дахь авлигын эрсдэлийг үнэлэх аргачлалыг турших, хэлэлцүүлэх.
Зөвлөхөд тавигдах шаардлага	Ерөнхий шаардлага: Зөвлөх баг нь дараах мэргэжил, туршлага бүхий 2-3 гишүүнээс бүрдэх бөгөөд багийг ахлах 1 гишүүнийг томилсон байна. • Зөвлөх багийн ахлагч нь эрх зүйч эсвэл төрийн удирдлагын мэргэжилтэй байх; Зөвлөх багийн гишүүд нь уул уурхай болон эдийн засгийн шинжлэх ухааны мэргэжилтэй байх; • Монгол Улсын засаглалын тогтолцоо, салбарын болон авлигын эсрэг хууль, эрх зүйн орчны талаар мэдлэгтэй байх; • Мэдээлэл цуглуулах боловсруулах арга зүй эзэмшсэн байх (Сургалтын батламж, бүтээлийн жагсаалтыг хавсралтаар илгээх) • Багийн нэг гишүүн англи хэлний бичгийн ур чадвар эзэмшсэн байх; • Эрсдэлийн удирдлага, үнэлгээний ажлын аргачлал боловсруулахад оролцож, үр дүн гаргасан байх. Бусад • Эрсдэлийн үнэлгээ, судалгаа, дүн шинжилгээний ажил 3-аас доошгүй жил эрхэлсэн туршлагатай; • Авлигын эсрэг үйл ажиллагаа, ил тод байдлын чиглэлээр ажиллаж, үр дүн гаргасан байх (давуу тал болно); • Тухайн салбарын аливаа зөвшөөрөл олгох, гэрээ байгуулах үйл явцад сүүлийн 2 жилд оролцоогүй байх.
Тайлангийн хуваарь	• Гэрээ байгуулж ажил эхэлснээс хойш хуанлийн 7 хоног тутамд ажлын явцыг цахимаар тайлагнаж байна; • Гэрээний хугацаанд 2-3 удаа явцын тайланг танилцуулах.
Үнэлгээний аргачлалд тавигдах шаардлага	• Монгол Улсын хууль, эрх зүйн зохицуулалтад нийцсэн байх; • Үнэлгээний шалгуур, арга зүй нь тодорхой, хэрэглэх боломжтой байх; • Стандартчилсан хэмжүүр, логик дараалалтай байх • Аргачлал нь нотолгоонд суурилсан байх • Мэдээллийн аюулгүй байдал, нууцлалын шаардлагыг хангасан байх
Ирүүлэх санал	Дээрх шаардлагыг хангасан этгээд дараах бичиг баримтыг бүрдүүлж ирүүлнэ: • Сонгон шалгаруулалтад оролцох хүсэлт /албан бичгээр/; • Зөвлөх багийн бүрэлдэхүүний талаарх мэдээлэл;

	• Боловсрол, ур чадварын талаарх мэдээлэл; • Ажлын туршлагын хураангуй, бүтээлийн жагсаалт, уг даалгаврыг гүйцэтгэх чадвартай болохыг нотолсон баримт бичиг; • Сүүлийн 5 жилийн хугацаанд гүйцэтгэсэн ижил төстэй ажлын талаарх танилцуулга /хамгийн багадаа 2 ажил/; • Даалгаврыг гүйцэтгэх хугацаа болон үнийн санал, зардлын тооцоолол;
--	---